



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 15 өдөр

Дугаар A/188

Бат-Өлзий сум

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл  
олгох тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 16 дугаар зүйлийн 16.3.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Л.Бямбасүрэн эзэнтэй “Тэрэлж” 6 нэрийн хүнсний дэлгүүрт тамхи худалдах тусгай зөвшөөрлийг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай олгосугай.
2. Тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж 100000 (нэг зуун мянган) төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Гааль, татварын улсын байцаагч (Н.Батсайхан)-д даалгасугай.
3. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгогдсон дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг Цагдаагийн хэсгийн дарга, Цагдаагийн ахмад (Д.Энх-Амгалан), Гааль, татварын улсын байцаагч (Н.Батсайхан), Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (М.Мягмаржав) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

